



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
210 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.7, 46.8 дахь хэсэг, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дугаар заалт, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн “Ногдол ашгийн журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 2024 оны цэвэр ашгийн 77.9 хувь буюу 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоон мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.

3. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулан, 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгосугай.

4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ